

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН  
2022 ОНЫ 16 ДУГААР ХУРАЛДААН**

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 16 дугаар хуралдааныг 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 14 цаг 10 минутад Нутгийн удирдлагын ордны II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 72.7 хувийн ирцтэй хуралдав.

| Д/д | Хэлэлцсэн асуудал  | Хурлаас гарсан шийдвэр   |
|-----|--|--|
| 1   | Төрийн дээд одон, медалиар шагнуулахаар ирүүлсэн иргэдийн материалыг хэлэлцүүлэх тухай                 | <p><b>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</b><br/>                     Аймаг, орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулан, боловсрол, эрүүл мэнд, барилга, авто тээвэр, банк санхүү, нийтийн аж ахуй үйлчилгээ, хөдөө аж ахуй зэрэг салбаруудын төр, хувийн хэвшлийн байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаад гавьяаныхаа амралтад гарсан ахмад настнууд болон ажиллаж байгаа хавсралтаар баталсан нэр бүхий иргэдийг төрийн дээд одон, медальд тодорхойлсон материалыг Монголын ахмадын холбоо болон холбогдох яамдад уламжлан дэмжсэн санал авч Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжлахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболд, тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Гантөмөр нарт үүрэг болгов.</p> |
| 2   | 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөл хэлэлцүүлэх тухай  | <p><b>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</b><br/>                     1. Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төсөл хэлэлцүүлэх явцад Зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд хугацаанд нь хүргүүлэхийг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Баярсүх, тус хэлтсийн мэргэжилтэн Л.Батгэрэл нарт үүрэг болгов.</p>  |
| 3   | Ахуйн зориулалтаар барих, агнах агнуурын амьтны тоо хэмжээний хязгаар батлах асуудал хэлэлцүүлэх тухай | <p><b>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</b><br/>                     Ахуйн зориулалтаар барих, агнах агнуурын амьтны тоо хэмжээний хязгаар батлах асуудал хэлэлцүүлэх явцад Зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг тусган ахуйн зориулалтаар агнах амьтны тоо хэмжээг сумдаар болон агнуурын бүс нутгаар гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд хугацаанд нь хүргүүлэхийг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Баярсүхэд үүрэг болгов.</p>   |
| 4   | Өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын хэсэг байгуулах асуудал хэлэлцүүлэх тухай                          | <p><b>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</b><br/>                     Хөдөө аж ахуйн салбарын болон хот суурин газрын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан байдлыг дүгнэх, хяналт үнэлгээ хийх ажлын удирдамжийг батлуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Баярсүхэд үүрэг болгов.</p>  |

|   |   |  |
|---|---|--|
| 5 | Төрийн их баяр наадмын түрүү бөх, Монгол Улсын шинэ аварга О.Хангай, Монгол Улсын заан Б.Бат-Өлзий, Монгол Улсын начин Б.Сосорбарам, Монгол Улсын мэргэн Б.Мөнхзориг нарт хүндэтгэл үзүүлэх | ШИЙДВЭРЛЭСЭН нь:<br>Төрийн их баяр наадмын түрүү бөх, Монгол Улсын шинэ аварга О.Хангай, Монгол Улсын заан Б.Бат-Өлзий, Монгол Улсын начин Б.Сосорбарам, Монгол Улсын мэргэн Б.Мөнхзориг нарт хүндэтгэл үзүүлэх асуудлыг хэлэлцүүлэх явцад Зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг тусгаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдалд үүрэг болгов. |
| 6 | “Төрийн тахилгат Алтан хөхий уулын түүх, соёл” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах зардлын асуудал хэлэлцүүлэх тухай  | ШИЙДВЭРЛЭСЭН нь:<br>Аялал жуулчлалын хөтөлбөрөөс “Төрийн тахилгат Алтан хөхий уулын түүх, соёл” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулахад зарцуулагдах 13.5 сая төгрөгийн зардал гаргах шийдвэрийн төсөл боловсруулан танилцуулахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Даваадоржид үүрэг болгов.   |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР